



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/047

Номгон

Ай ти эм-2021 олон улсын аялал жуулчлалын
үзэсгэлэнд оролцох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30.1.17 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 2/8 дугаар тогтоолоор баталсан, Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний батлагдсан хавсралтын 80 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ

1. Улаанбаатар хотод 2021 оны 10 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Ай Ти Эм” олон улсын үзэсгэлэнд аймаг орон нутгаа сурталчлах ажлын хэсгийг нэгдүгээр, шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хасвралтаар тус тус баталсугай.

2. “Ай Ти Эм” үзэсгэлэнд шаардагдах 2.990.500 (Хоёр сая есөн зуун ерэн мянга таван зуун) төгрөгийг аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3. “Ай Ти Эм” -2021 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд өндөр зохион байгуулалттай оролцож, тайланг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Э.Ганзориг)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601210509

Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын
19-ний өдрийн А/647 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Ганзориг

(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон
гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга:

Д.Содномсамдан

(Байгаль орчин, аялал жуулчлалын газрын аялал жуулчлал хариуцсан
ахлах мэргэжилтэн)

Гишүүд :

Д.Болормаа (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын аялал жуулчлал
хариуцсан мэргэжилтэн)

М.Батбаяр (“Баянхонгор-Хүн үүслийн өлгий” аялал жуулчлалын холбооны
тэргүүн)

Г.Алтанцэцэг (Шаргалжуут сарлагийн буян нөхөрлөлийн гишүүн)

Т.Хишигхүү (“Улайтайн ам” нөхөрлөлийн ахлагч)

Б.Баянмөнх (“Баянсайр” жуулчны баазын захирал)

Т.Төмөрбаатар (“Өгөөж булган” жуулчны баазын захирал)

_____ оОо _____

Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын
19-ний өдрийн А/647 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт

АЙ ТИ ЭМ -2021 ОНЫ ОЛОН УЛСЫН АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ҮЗЭСГЭЛЭНД ОРОЛЦОХ ЗАРДЛЫН
ТООЦОО

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Тайлбайн түрээс	мкв	9	78.000	702.000
2	Шатахууны зардал	литр	360	2550	918.000
3	Талбайн тохижилт /Эх бэлтгэл, прүсс мод, даавуун хэвлэл, ажлын хөлс, тээвэр/	мкв	9	800.000	800.000
4	Тавгийн ааруул	кг	4	18.000	72.000
5	Хар талх	ширхэг	10	3.500	35.000
6	Нэг удаагийн таваг	Боодол	1	10.000	10.000
7	Хуурай салфетка	Боодол	1	3.500	3.500
8	Аймгаас оролцох үйлчилгээний байгууллагуудын төлөөллийн замын зардал/ ирж, очих/		5	90.000	450.000
9	Нийт				2.990.500

оОо